

**ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР**

2017 оны 01 дүгээр сарын 05



Улаанбаатар хот

**Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага,
албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн талаар**

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2016 онд иргэд, байгууллагаас 9306 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 315 нэгж буюу 3.3 хувиар буурчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 211 буюу 2.3 хувь нь санал, 8881 буюу 95.4 хувь нь

**Нийт хүлээн авсан санал, өргөдөл,
гомдол**



өргөдөл, 214 буюу 2.3 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 1232 буюу 13.2 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 324 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1497 буюу 16.1 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2305 буюу 24.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 422 буюу 4.5 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 3526 буюу 37.9 хувь нь бусад өргөдөл гомдол байна.





Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 9217 буюу 99 хувийг шийдвэрлэж, 89 буюу 1 хувь нь ажиллагаанд байна.


Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2016 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 747 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 208 нэгж буюу 21.8 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 1 буюу 0.1 хувь нь санал, 30 буюу 4.0 хувь нь гомдол, 716 буюу 95.9 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн ерөнхий газрын удирдлагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 68 буюу 9.1 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 94 буюу 12.6 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 94 буюу 12.6 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 24 буюу 3.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 75 буюу 10.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 392 буюу 52.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2016 онд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 554 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 210 буюу 38.0 хувь нь санал хүсэлт, 244 буюу 44.0 хувь нь гомдол, 78 буюу 14.1 хувь нь талархал, 19 буюу 3.4 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.5 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 464 буюу 83.8 хувийг шийдвэрлэж, 90 буюу 16.2 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 168 буюу 30.3 хувийг 5 хоногийн дотор, 386 буюу 69.7 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2016 онд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1705 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 120 нэгж буюу 6.6 хувиар буурч, 1913 алба хаагч холбогдсоны 1584 буюу 82.8 хувь нь офицер, 320 буюу 16.7 хувь нь ахлагч, 9 буюу 0.5 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 1650 буюу 96.8 хувийг барагдуулж, 55 буюу 3.2 хувь нь ажиллагаанд байна.

